



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/49.

Улаанбаатар хот

┌ Зөвлөгөөн зохион байгуулах тухай ┐

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, Нийслэлийн Засаг даргын нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн 2014 оны 09 сарын 10-ны өдөр баталсан удирдамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4, 4,9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын 375 жилийн ой, Монгол Улсад аялал жуулчлалын салбар үүсэж хөгжсөний 60 жилийн ойн хүрээнд нийслэл хотын аялал жуулчлал, соёл урлаг, спорт, зочлох үйлчилгээний байгууллагуудын "Найрсаг Улаанбаатар" зөвлөгөөнийг 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/, жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/ нарт даалгасугай.

2. Зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 2.450.000 /хоёр сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2014 оны 09 сарын 11 өдрийн
А/149 тоот тушаалын хавсралт



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Зөвлөгөөний маягт материал хэвлүүлэх багц зардал /санал асуулгын маягт 2 төрөл, урилга, эвентийн хуанли, Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлуудын тайлан/	1	2.450.000	2.450.000
	Дүн	1	2.450.000	2.450.000

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА

Огноо: 2014.09.11

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХЗУЛ

Огноо: 2014.09.11